**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА**

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Ховд аймгийн Биеийн тамир спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**Аудитын код: ХОА-2022/86/НА/-СТА-ТШЗ**


Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас:70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: А.Нарандэлгэр

Утас: 70432545

цахим хаяг: narandelgera@audit.gov.mn


Цахим хуудас: www.audit.mn

Ховд хот

2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.......... 3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .......... 3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .......... 4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .......... 6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.......... 6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .......... 8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .......... 9
3. Аудитын тайлан .......... 9
3.1 Ерөнхий зүйл.......... 9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .......... 10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.......... 10
3.4 Материаллаг байдал .......... 10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.......... 10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .......... 11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .......... 12
3.8 Аудитын гол асуудал .......... 12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.......... 12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .......... 12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .......... 12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .......... 12
4. Аудитын илрүүлэлт.......... 12
4.1 Залруулсан алдаа.......... 13
4.2 Төлбөрийн акт.......... 13
4.3 Албан шаардлага .......... 13
4.4 Зөвлөмж .......... 13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .......... 14

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| НА | Нотлох ажил |

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2022.02.17 № 2/34
танай ____________-ны №____________-т

БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГА Ч.ТҮМЭНДЭМБЭРЭЛ

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Биеийн тамир спортын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Биеийн тамир спортын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

021020172

# 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **50,696,471.26** | **18,596,600.05** |
| **33** | **АВЛАГА** | 14,216,121.26 | 578,100.05 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 900,000.00 | 578,100.05 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 196,121.26 | 00.00 |
| **335** | **Бусад авлага** | 13,120,000.00 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 13,120,000.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 36,480,350.00 | 18,018,500.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 19,800,750.00 | 6,172,500.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 19,800,750.00 | 6,172,500.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 6,505,000.00 | 3,199,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 10,174,600.00 | 8,647,000.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 873,000.00 | 447,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 300,000.00 | 300,000.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 40,500.00 | 272,500.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 7,472,000.00 | 7,021,500.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,489,100.00 | 606,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,061,968,225.91** | **2,880,198,238.60** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,061,968,225.91 | 2,880,198,238.60 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,884,024,225.91 | 2,700,779,238.60 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,589,632,943.57 | 3,589,632,943.57 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -933,355,689.09 | -1,093,988,648.10 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 71,789,584.00 | 71,789,584.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -5,106,666.64 | -13,125,625.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 231,957,837.33 | 226,037,733.43 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -129,120,168.27 | -131,772,467.57 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 59,288,737.29 | 55,126,858.06 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -44,043,674.38 | -44,019,357.57 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 45,801,530.74 | 45,801,530.74 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -12,820,208.64 | -14,703,312.96 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 10,000,000.00 | 10,000,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 177,944,000.00 | 179,419,000.00 |
| 39301 | Програм хангамж | 880,000.00 | 2,380,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -880,000.00 | -905,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 177,944,000.00 | 177,944,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,112,664,697.17** | **2,898,794,838.65** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **65,860,320.00** | **33,102,339.72** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 65,860,320.00 | 33,102,339.72 |
| **413** | **Өглөг** | 65,860,320.00 | 33,102,339.72 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 328,765.32 |
| 41340 | Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг | 13,120,000.00 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 52,740,320.00 | 32,773,574.40 |

| | | | |
|---|---|---|---|
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 52,740,320.00 | 32,773,574.40 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,046,804,377.18** | **2,865,692,498.94** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,046,804,377.18 | 2,865,692,498.94 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 680,905,756.00 | 680,905,756.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 503,461,756.00 | 503,461,756.00 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг | 177,444,000.00 | 177,444,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -182,557,493.38 | -363,669,371.62 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -182,557,493.38 | -182,557,493.38 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -181,111,878.24 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,548,456,114.55 | 2,548,456,114.55 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,112,664,697.18** | **2,898,794,838.65** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **686,220,284.00** | **578,207,320.82** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **169,789,584.00** | **2,390,520.82** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 169,789,584.00 | 15,270,720.82 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 169,789,584.00 | 15,270,720.82 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 500,000.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 22,500,000.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 146,789,584.00 | 15,270,720.82 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **516,430,700.00** | **575,816,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 00.00 | 275,392,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 275,392,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 18,835,000.00 | 32,824,200.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 18,835,000.00 | 7,930,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 8,474,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 3,540,000 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 497,595,700.00 | 267,600,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 497,595,700.00 | 267,600,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **767,635,955.76** | **759,319,199.06** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **767,635,955.76** | **759,319,199.06** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 745,365,186.03 | 750,444,592.26 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 203,514,943.20 | 210,099,696.16 |
| 210101 | Үндсэн цалин | 203,514,943.20 | 171,154,596.16 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 38,945,100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 24,860,515.50 | 27,555,067.31 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,096,844.00 | 19,199,352.11 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,019,389.50 | 2,257,359.98 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,609,116.00 | 1,680,797.59 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 375,926.00 | 401,596.15 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,759,240.00 | 4,015,961.48 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 249,738,745.50 | 247,633,254.40 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,259,915.50 | 2,869,123.40 |
| 210302 | Түлш, халаалт | 234,661,350.00 | 234,661,350.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,817,480.00 | 10,102,781.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,767,840.00 | 5,828,877.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 517,000.00 | 1,004,250.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,000,000.00 | 2,507,247.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 108,840.00 | 597,380.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 490,000.00 | 360,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 652,000.00 | 1,360,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 48,000.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 48,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 1,085,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 1,085,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 231,900.00 | 952,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 231,900.00 | 952,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,876,469.00 | 6,631,587.26 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,969,760.00 | 6,631,587.26 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 242,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 39,120.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 35,000.00 | 00.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 7,800.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 300,000.00 | 00.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 282,789.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 257,326,772.83 | 250,658,510.13 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 59,663,200.00 | 52,118,002.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 197,663,572.83 | 198,540,508.13 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 22,270,769.73 | 8,874,606.80 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 13,120,769.73 | 00.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 13,120,769.73 | 00.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 9,150,000.00 | 1,033,400.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 8,750,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 400,000.00 | 1,033,400.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 7,841,206.80 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 7,841,206.80 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-81,415,671.76** | **-181,111,878.24** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-81,415,671.76** | **-181,111,878.24** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 680,905,756.00 | 2,548,456,114.56 | -82,856,521.62 | 3,146,505,348.93 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | -18,285,300.00 | -18,285,300.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **680,905,756.00** | **2,548,456,114.56** | **-101,141,821.62** | 3,128,220,048.93 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -81,415,671.76 | -81,415,671.76 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **680,905,756.00** | **2,548,456,114.56** | **-182,557,493.38** | 3,046,804,377.17 |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **680,905,756.00** | **2,548,456,114.56** | **-182,557,493.38** | 3,046,804,377.17 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **680,905,756.00** | **2,548,456,114.56** | **-182,557,493.38** | 3,046,804,377.17 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -181,111,878.24 | -181,111,878.24 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **680,905,756.00** | **2,548,456,114.56** | **-363,669,371.62** | 2,865,692,498.93 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **539,430,700.00** | **575,816,800.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **23,000,000.00** | **00.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 23,000,000.00 | 00.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 23,000,000.00 | 00.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 500,000.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 22,500,000.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **516,430,700.00** | **575,816,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 00.00 | 275,392,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 275,392,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 18,835,000.00 | 32,824,200.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 18,835,000.00 | 7,930,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 8,474,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 16,420,200.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 497,595,700.00 | 267,600,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 497,595,700.00 | 267,600,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **539,430,700.00** | **575,816,800.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **539,430,700.00** | **575,816,800.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **517,159,930.27** | **566,942,193.20** |

| | | | |
|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 201,269,125.43 | 209,855,260.20 |
| 210101 | Үндсэн цалин | 165,706,428.43 | 178,253,914.15 |
| 210102 | Нэмэгдэл | 35,562,697.00 | 31,601,346.05 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 28,201,070.34 | 27,069,939.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,575,670.34 | 19,505,433.42 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,156,300.00 | 1,938,738.85 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,725,000.00 | 1,550,991.07 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 431,500.00 | 370,434.16 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,312,600.00 | 3,704,341.50 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 215,283,725.50 | 249,100,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,259,915.50 | 2,869,123.40 |
| 210302 | Түлш, халаалт | 200,206,330.00 | 236,128,095.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,817,480.00 | 10,102,781.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,870,840.00 | 4,617,094.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 517,000.00 | 490,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,000,000.00 | 2,167,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 163,840.00 | 597,380.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 490,000.00 | 661,714.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 700,000.00 | 700,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 200,000.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 200,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 204,200.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 204,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 231,900.00 | 952,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 231,900.00 | 952,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,556,469.00 | 8,319,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,649,760.00 | 8,319,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 242,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 39,120.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 35,000.00 | 00.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 7,800.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 300,000.00 | 00.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 282,789.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 60,546,800.00 | 66,824,200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 60,546,800.00 | 66,824,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **22,270,769.73** | **8,874,606.80** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 13,120,769.73 | 00.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 13,120,769.73 | 00.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 9,150,000.00 | 1,033,400.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 8,750,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 400,000.00 | 1,033,400.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 7,841,206.80 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 7,841,206.80 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **00.00** |

| | | | |
|---|---|---|---|
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **00.00** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 542,992,600.00 | 535,151,393.20 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 542,992,600.00 | 535,151,393.20 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 541,959,200.00 | 534,117,993.20 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 215,627,500.00 | 209,855,260.20 |
| 210101 | Үндсэн цалин | 180,193,700.00 | 178,253,914.15 |
| 210102 | Нэмэгдэл | 35,433,800.00 | 31,601,346.05 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 29,109,800.00 | 27,069,939.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,484,600.00 | 19,505,433.42 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,156,300.00 | 1,938,738.85 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,725,000.00 | 1,550,991.07 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 431,300.00 | 370,434.16 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,312,600.00 | 3,704,341.50 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 249,100,000.00 | 249,100,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,100,000.00 | 2,869,123.40 |
| 210302 | Түлш, халаалт | 234,500,000.00 | 236,128,095.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,500,000.00 | 10,102,781.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,637,200.00 | 4,617,094.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 490,000.00 | 490,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,167,500.00 | 2,167,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 612,500.00 | 597,380.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 666,700.00 | 661,714.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 700,500.00 | 700,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 204,200.00 | 204,200.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 204,200.00 | 204,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 961,000.00 | 952,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 961,000.00 | 952,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,319,500.00 | 8,319,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,319,500.00 | 8,319,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 34000000.00 | 34000000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 34,000,000.00 | 34,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1033400.00 | 1033400.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,033,400.00 | 1,033,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,033,400.00 | 1,033,400.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 542,992,600.00 | 535,151,393.20 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 275,392,600.00 | 267,551,393.20 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 275,392,600.00 | 267,551,393.20 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 267,600,000.00 | 267,600,000.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 267,600,000.00 | 267,600,000.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 25.00 | 25.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 14.00 | 14.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 10.00 | 10.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **41,335,000** | **32,824,200** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **41,335,000** | **32,824,200** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 28,214,800 | 32,824,200 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 28,214,800 | 32,824,200 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 28,214,800 | 32,824,200 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **41,335,000** | **32,824,200** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **41,335,000** | **32,824,200** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 18,835,000 | 7,930,000 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 22,500,000 | 8,474,000 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 16,420,200 |

# 3. Аудитын тайлан

## 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Биеийн тамир спортын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал

татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор А.Нарандэлгэр 2022 оны 01 дүгээр сарын 24-нээс 2021 оны 02 дугаар сарын 16–ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ховд аймгийн Биеийн тамир спортын газар нь “Биеийн тамираар хичээллэгчид, ¿éë÷ë¿¿ëýã÷èääýý áàéí ãû í èäýâõòýé õº äº ëãº º í á¿õèé àæðº ðº õ ¸ ñ ñóðòàõóóí á¿õèé ääääë ðº ëº âø ¿¿ëýõýä òóñëàã÷ í ü áàéæ òèâ, äýëõèé, î ëèì ï èéí í àäääì ä º ðñº ëäº õ òàì èð÷äû í çàëãàì æ õàëàää ðº рүүлэн гаргах” зорилгын хүрээнд 3 зорилт дэвшүүлэн 55 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 759.5 сая төгрөгөөс 1.5 хувиар тооцон 11.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 8.5 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ховд аймгийн Биеийн тамир спортын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 213.8 сая төгрөгөөр буюу 6.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Тайлант онд авлага 13.6 сая төгрөгөөр буурсан нь өмнөх онд үндсэн хөрөнгө бэлтгэхтэй холбоотой үүссэн авлага барагдаж, 0.6 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 18.0 сая төгрөг болж 18.5 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 17.2 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, 4.9 сая төгрөгийн бараа материал акталж, үйл ажиллагаандаа 30.8 сая төгрөгийн бараа материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 3061.9 мянган төгрөг, оны эцэст 2880.2 сая төгрөг болж 181.7 сая төгрөгөөр буурсан нь 25.4 сая төгрөгийн хөрөнгө акталсан, тайлант оны элэгдлийн зардалтай холбоотой байна.

Тайлант онд 14.4 сая төгрөгийн хөрөнгө төсвөөс бэлтгэж, 2.4 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 25.4 сая төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл оны эхэнд 65.8 сая төгрөг, оны эцэст 33.1 сая төгрөг болж 32.7 сая төгрөгөөр буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 3046.8 сая төгрөг байсан оны эцэст 2865.7 сая төгрөг болж тайлант онд 181.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 363.7 сая төгрөг болсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Ховд аймгийн Биеийн тамир спортын газрын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 625.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 588.8 сая төгрөгөөр батлан ирүүлжээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 588.8 сая төгрөгийн төсөв батлагдаж, 581,2 сая төгрөгийг төсвөөс, 7.6 сая төгрөгийг өөрийн орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 275.4 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 267.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 535.2 сая төгрөгийг зарцуулж, 7.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Тайлант онд төсвийн тодотгол 2 удаа хийж, улсын төсвийн санхүүжилтийг 56.7 сая төгрөгөөр хасаж, тогтмол зардлын санхүүжилтийг 18.5 сая төгрөгөөр нэмсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 535.2 сая төгрөг буюу 98.5 хувьтай байгаа нь Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлын 5.7 сая төгрөг, Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 2.0 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар 32.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 32.8 сая төгрөгийн зардлыг бараа ажил үйлчилгээний зардалд зарцуулсан байна.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

## 3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

## 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих мэдээллийг 87.1 хувьтай мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

## 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 1 төлбөрийн актыг бүрэн барагдуулж, 5 зөвлөмжийг биелүүлж ажилласан байна.

## 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байхгүй болно.

# 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 22.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 15.9 сая төгрөгийн алдааг залруулж, 2.5 сая төгрөгийн 2 алдаа зөрчилд төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3.8 сая төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Үр дүнгийн тайлангийн цалингийн зардлыг буруу тайлагнасан 0,9 сая төгрөг
2. Шилжиж ирсэн хөрөнгийг бүртгэхдээ дансны бичилт буруу хийж тайланд оны үр дүнг зөрүүтэй илэрхийлсэн 1.1 сая төгрөг
3. Ажиллагсадтай холбоотой авлагыг данс бүртгэлд тусгаагүй 0.5 сая төгрөг
4. Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг зөрүүтэй илэрхийлсэн 0.3 сая төгрөг
5. Авлага буурсан дүнгээр үр дүнгийн тайланд орлого хүлээн зөвшөөрөөгүй 13,1 сая төгрөг

***<u>Шийдвэрлэсэн нь</u>***: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 15.9 сая төгрөгийн залруулга хийж, залруулсан 2022 оны 02 дугаар сарын 16-ны 08 тоот албан бичгээр санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

### 4.2 Төлбөрийн акт

1. ХАОАТ-ын хөнгөлөлтийг давхардуулах тооцсон 0.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Хувь хүний орлогын албан татварын хуулийн 23.1.Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт / 0-6,0 сая төгрөгийн орлогод 0,24 сая төгрөг /дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах"гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

2. Ээлжийн амралтын олговрыг цалинтай давхардуулан 0.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 20 зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан баталгаажуулах" заалттай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Төлбөрийн акт тогтоов.

### 4.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### *4.4.1 Дотоод хяналттай холбоотой асуудал*

*4.4.1.1* *<u>Илрүүлэлт</u>* Засгийн газрын 2020 оны "Айл өрх, аж ахуйн нэгж байгууллагад дэмжлэг үзүүлэх тухай" 211-р тогтоолтой давхардуулан 3.9 сая төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлтийг орон сууцанд амьдардаг албан хаагчдад олгосон.

4.4.1.2 *<u>Өгсөн зөвлөмж</u>* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах", Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.

*<u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>* *Үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрсөн*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Биеийн тамир спортын газар | 8 | 21.0 | 5 | 15.9 | 2 | 1.2 | - | - | 1 | 3.9 |

**Ховд аймаг дахь Төрийн аудитын газар**